ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 01 сарын 09 өдөр Дугаар 02 Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг явагдаагүйд тооцож, дахин зохион байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 29 дүгээр зүйлийн 1, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 102 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, "Роял Грийн Вилла" хотхоны 62/8 (202) дугаар байрны Б1/103 тоотод байрлах 160 м.кв талбай бүхий орон сууц, мөн байрны зоорийн давхрын 2 (5) тоот автомашины зогсоолыг, Г62/10 дугаар байрны 59 тоот автомашины зогсоолын хамт худалдах нээлттэй дуудлагын худалдааг 2017 оны 09 дүгээр 08-ны өдөр зохион байгуулсан боловч оролцогч ирээгүй тул дуудлагын худалдааг явагдаагүйд тооцож, дахин зохион байгуулсугай.

2.Дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн доод үнийг хавсралтад заасны дагуу тооцож, нийт худалдах доод үнийг 391,000,000.00 (гурван зуун ерэн нэгэн сая) төгрөгөөр, дэнчингийн хэмжээг худалдах доод үнийн 15 хувиар буюу 58,650,000.00 (тавин найман сая зургаан зуун тавин мянган) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай.

3.Дуудлагын худалдааны орлогоос орон сууц, зогсоолын ашиглалтын зардлыг суутган тооцож, холбогдох байгууллагад төлж барагдуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт зөвшөөрсүгэй.

4.Дуудлагын худалдааны орлогоос тогтоолын 3-т заасан зардлыг хасч улсын төсөвт төвлөрүүлсүгэй.

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.ЭРДЭНЭХИШИГ

0001367

D:\Huraldaanii material\2018 on\2018.01.09\togtool\01docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн
02 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ДАХИН ХУДАЛДАХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

Д/д	Хөрөнгийн нэр, байршил	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 252 дугаар тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 329 дүгээр тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)
1	Орон сууц, автомашины зогсоол (Хан-Уул дүүрэг, 11-р хороо, “Роял Грийн Вилла” хотхоны 62/8 дугаар байрны Б1/103, Г62/10 байрны зогсоол)	700,000,000.00	420,000,000.00	378,000,000.00
2	Орон сууцны ашиглалтын зардал (сууц эзэмшигчдийн холбоонд төлөх өр)	10,407,701.00	11,000,000.00	13,000,000.00
	Нийт дүн	710,407,701.00 (долоон зуун арван сая дөрвөн зуун долоон мянга долоон зуун нэг)	431,000,000.00 (дөрвөн зуун гучин нэгэн сая)	391,000,000.00 (гурван зуун ерэн нэгэн сая)